

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/260/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:tsogbayara@audit.gov.mn">tsogbayara@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Б.Ариунжаргал Утас: Цахим хаяг: <a href="mailto:ariunjargal@audit.gov.mn">ariunjargal@audit.gov.mn</a> Сүлд-Аудит ХХК-ийн захирал: Ч.Гүндбаяр Утас: 70118016 Цахим хаяг: <a href="mailto:info@suld-audit.mn">info@suld-audit.mn</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын талаар .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага .....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....	20
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....	20
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	21

## Товчилсон үгийн жагсаалт

---

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СНАГ	Санхүү-Нийцлийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГБХНЯ	Гэр Бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаасан өвчин
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/363

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 119,130.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант онд хөрөнгө оруулалтын төсөв батлуулаагүй байхад 79,944.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн;
- Албан томилолтын зарцуулалтыг урьдчилгаа тооцоогоор тайлагнаагүй, гүйцэтгэлийг хянаагүй, 18,712.4 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл нь дутуу зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-ын заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэн зөв болон нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 138 дугаар тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг байгуулсан бөгөөд 2025 оны 2 дугаар сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Үүнтэй холбоотойгоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 271 дугаар тогтоолын дагуу “Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллага”-аас 6,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгсэл, Гэр Бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам” -аас 69,589.3 мянган төгрөгийн үнэ бүхий машин, тоног төхөөрөмж, Аж ахуйн нэгжээс 4,960.0 мянган төгрөгийн үнэ бүхий тавилга эд хогшил, нийт 80,549.3 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор хүлээн авсан бүртгэсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн Ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газартай хамтран “Цогц арга хэмжээ” нэртэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нээлттэй өдөрлөгийг Хөвсгөл, Дундговь, Баян-Өлгий аймгуудад амжилттай зохион байгуулж, уг арга хэмжээний зардалд 8,021.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## **Бусад асуудал**

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн А/483 дугаар тушаалын дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарлаж, үүний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны иргэдийн хувь хүний ур чадвар, туршлага, ажиллах хүсэлтэй байгаа чиглэл, түүнд чиглэсэн ур чадварыг сайжруулах хэрэгцээг тодорхойлох судалгааг Монгол Улсын хэмжээнд нэгтгэн авч, үр дүнг тайлагнах явцтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>265,750.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		<b>265,750.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>		<b>265,750.00</b>
35410	Бичиг хэргийн материал		33,100.00
35420	Аж ахуйн материал		232,650.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>143,566,122.44</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		<b>143,566,122.44</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>		<b>142,006,122.44</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл		6,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(1,166,666.69)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		97,766,705.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(10,262,988.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		54,927,280.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		(5,258,207.75)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		<b>1,560,000.00</b>
39301	Программ хангамж		1,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(240,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>143,831,872.44</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>6,271,756.22</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>6,271,756.22</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>		<b>6,271,756.22</b>
41360	Бусад өглөг		6,271,756.22
41361	Байгууллагад төлөх өглөг		5,800,000.00
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/		471,756.22
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>137,560,116.22</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>137,560,116.22</b>
51200	Хуримтлагдсан үр дүн		137,560,116.22
51220	Тайлант үеийн үр дүн		137,560,116.22
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>143,831,872.44</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>1,305,268,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>1,305,268,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		<b>82,739,300.00</b>
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>		<b>1,890,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,890,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		80,549,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		300,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>		<b>1,222,529,200.00</b>
<b>1221</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>		<b>1,222,529,200.00</b>
<b>12211</b>	<b>Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого</b>		<b>1,222,529,200.00</b>
122111	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,222,529,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>1,167,708,383.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>1,167,708,383.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>955,933,990.57</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>		<b>717,379,041.04</b>
210101	Үндсэн цалин		403,134,315.10
210102	Нэмэгдэл		124,076,388.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт		153,030,387.57
210104	Урамшуулал		37,137,950.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>89,038,130.65</b>
210201	Тэтгэврийн даатгал		60,525,026.51
210202	Тэтгэмжийн даатгал		6,670,246.31
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,440,883.22
210204	Ажилгүйдлийн даатгал		3,290,878.34
210205	Эрүүл мэндийн даатгал		14,111,096.27
<b>2104</b>	<b>Хангамж бараа материалын зардал</b>		<b>35,442,883.32</b>
210401	Бичиг хэрэг		6,554,200.00
210402	Тээвэр, шатахуун		2,372,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		5,384,318.32
210404	Ном, хэвлэл		1,989,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,844,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		17,297,965.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		<b>93,500.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		93,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>14,157,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		352,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын зардал		988,000.00
210604	Урсгал зардал		12,817,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>19,798,000.00</b>
210702	Дотоод томилолтын зардал		19,798,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>51,275,895.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		45,639,995.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		5,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		267,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		268,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>28,749,240.56</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		11,821,378.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		16,927,862.56
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>211,774,393.21</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>		<b>211,774,393.21</b>
<b>21311</b>	<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>		<b>211,774,393.21</b>

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		211,774,393.21
2131121	Санхүүжилтийн үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		211,774,393.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		137,560,116.22
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (6)=(3+4-5)		137,560,116.22

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		1,223,380,087.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,223,380,087.00
1200	Нийтлэг татварын бус орлого		850,887.00
12004	Төсөв байгууллагын өөрийн орлого		850,887.00
120042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		850,887.00
122	Тусламжийн орлого		1,222,529,200.00
1221	Хандив тусламж /дотоод/		1,222,529,200.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого		1,222,529,200.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого		1,222,529,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,144,235,402.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,144,235,402.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		932,461,008.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		716,902,940.82
210101	Үндсэн цалин		402,658,602.45
210102	Нэмэгдэл		124,181,189.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт		152,925,199.04
210104	Урамшуулал		37,137,950.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		89,042,474.65
210201	Тэтгэврийн даатгал		60,529,370.51
210202	Тэтгэмжийн даатгал		6,670,246.31
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,440,883.22
210204	Ажилгүйдлийн даатгал		3,290,878.34
210205	Эрүүл мэндийн даатгал		14,111,096.27
2104	Хангамж, бараа материалын зардал		35,408,633.32
210401	Бичиг хэрэг		6,554,200.00
210402	Тээвэр, шатахуун		2,372,000.00
210403	Шуудан, холбоо, интернэт		5,384,318.32
210404	Ном, хэвлэл		1,989,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,844,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		17,263,715.00
2105	Нормативт зардал		93,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		93,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		14,157,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		352,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		988,000.00
210604	Урсгал засварын зардал		12,817,300.00
2107	Томилот, зочны зардал		19,798,000.00
210702	Дотоод томилолтын зардал		19,798,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		45,236,782.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		44,600,882.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		267,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		268,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		100,000.00

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2109</b>	<b>Бараа ажил үйлчилгээний бусад зардал</b>		<b>11,821,378.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		11,821,378.00
<b>213</b>	<b>Урсгал шилжүүлэг</b>		<b>211,774,393.21</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>		<b>211,774,393.21</b>
<b>21311</b>	<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>		<b>211,774,393.21</b>
<b>213112</b>	<b>Төсвийн байгууллагаас харъяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал</b>		<b>211,774,393.21</b>
2131121	Санхүүжилтийн үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		211,774,393.21
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (II)</b>		<b>79,144,685.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		<b>79,144,685.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>79,144,685.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>79,144,685.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		79,144,685.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		<b>(79,144,685.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		<b>0.00</b>
<b>20</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>0.00</b>
<b>99</b>	<b>Хамаарахгүй</b>		<b>0.00</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/төгрөгөөр/*

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>			
Тайлант үеийн үр дүн			
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>			
Тайлант үеийн үр дүн	-	137,560,116.22	137,560,116.22
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>137,560,116.22</b>	<b>137,560,116.22</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,275,217,200.0</b>	<b>1,011,605,693.79</b>	<b>23,611,506.21</b>	<b>79.3</b>
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>1,275,217,200.0</b>	<b>1,011,605,693.79</b>	<b>23,611,506.21</b>	<b>79.3</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		<b>850,887.00</b>	<b>(850,887.00)</b>	
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого		850,887.00	(850,887.00)	
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>1,275,217,200.00</b>	<b>1,010,754,806.79</b>	<b>264,462,393.21</b>	<b>79.3</b>
122005	Төсвөөс санхүүжих	1,275,217,200.00	1,010,754,806.79	263,611,506.21	79.3
<b>2</b>	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>1,275,217,200.00</b>	<b>1,011,605,693.79</b>	<b>263,611,506.21</b>	<b>79.3</b>
<b>21</b>	<b>Урсгал зардал</b>	<b>1,275,217,200.00</b>	<b>1,011,605,693.79</b>	<b>263,611,506.21</b>	<b>79.3</b>
<b>210</b>	<b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>1,275,217,200.00</b>	<b>1,011,605,693.79</b>	<b>263,611,506.21</b>	<b>79.3</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>897,367,200.00</b>	<b>716,902,940.82</b>	<b>180,464,259.18</b>	<b>79.9</b>
210101	Үндсэн цалин	426,993,100.00	402,658,602.45	24,334,497.55	94.3
210102	Нэмэгдэл	194,310,900.00	124,181,189.33	70,129,710.67	63.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	191,446,600.00	152,925,199.04	38,521,400.96	79.9
210104	Урамшуулал	84,616,600.00	37,137,950.00	47,478,650.00	43.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>119,833,300.00</b>	<b>89,042,474.65</b>	<b>30,790,825.35</b>	<b>74.3</b>
210201	Тэтгэврийн даатгал	80,110,900.00	60,529,370.51	19,581,529.49	75.6
210202	Тэтгэмжийн даатгал	9,916,200.00	6,670,246.31	3,245,953.69	67.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,994,300.00	4,440,883.22	553,416.78	88.9
210204	Ажилгүйдлийн даатгал	4,958,100.00	3,290,878.34	1,667,221.66	66.4
210205	Эрүүл мэндийн даатгал	19,853,800.00	14,111,096.27	5,742,703.73	71.1
<b>2104</b>	<b>Хангамж бараа материалын зардал</b>	<b>68,571,200.00</b>	<b>36,776,433.32</b>	<b>31,794,766.68</b>	<b>53.63</b>
210401	Бичиг хэрэг	7,394,600.00	6,554,200.00	840,400.00	88.6
210402	Тээвэр, шатахуун	4,445,500.00	2,372,000.00	2,073,500.00	53.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,774,100.00	5,384,318.32	7,389,781.68	42.2
210404	Ном, хэвлэл	1,989,900.00	1,989,900.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,681,800.00	1,844,500.00	7,837,300.00	19.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,285,300.00	18,631,515.00	13,653,785.00	57.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,846,900.00</b>	<b>93,500.00</b>	<b>2,753,400.00</b>	<b>3.28</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,846,900.00	93,500.00	2,753,400.00	3.3
<b>2106</b>	<b>Эд хогшил урсгал засварын зардал</b>	<b>95,855,400.00</b>	<b>90,934,185.00</b>	<b>4,921,215.00</b>	<b>94.99</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	67,202,900.00	67,202,885.00	15.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,909,200.00	988,000.00	4,921,200.00	16.7
210604	Урсгал засварын зардал	22,743,300.00	22,743,300.00	-	100.0
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>21,000,000.00</b>	<b>19,798,000.00</b>	<b>1,202,000.00</b>	<b>94.3</b>
210702	Дотоод томилолтын зардал	21,000,000.00	19,798,000.00	1,202,000.00	94.3
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>56,267,900.00</b>	<b>46,236,782.00</b>	<b>10,031,118.00</b>	<b>82.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,600,900.00	44,600,882.00	18.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,167,100.00	0.00	7,167,100.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	403,100.00	0.00	403,100.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	340,400.00	267,900.00	72,500.00	78.7

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	268,800.00	268,000.00	800.00	99.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,487,600.00	1,100,000.00	2,387,600.00	31.5
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,475,300.00</b>	<b>11,821,378.00</b>	<b>1,653,922.00</b>	<b>87.7</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,475,300.00	11,821,378.00	1,653,922.00	87.7
<b>8</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>				
<b>9</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>				
<b>7</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>				
<b>6</b>	<b>Төсвийн бусад мэдээллийн ангилал</b>	<b>65</b>	<b>65</b>	<b>0</b>	<b>100.0</b>
<b>61</b>	<b>Байгууллагын тоо</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
<b>62</b>	<b>Ажиллагсадын тоо</b>	<b>32</b>	<b>32</b>	<b>0</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	4	5	(1)	125.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22	26	(4)	118.2
620003	Үйлчлэх ажилтан	6	1	5	83.3
<b>65</b>	<b>Орон тооны мэдээлэл</b>	<b>32</b>	<b>32</b>	<b>0</b>	<b>100.0</b>
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	32	32	0	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв нь хүртээмжтэй, өсөн дэвжих ажлын байрны тогтолцоог хэвшил болгох эрхэм зорилтын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөр эрхлэх боломж нөхцөлийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бие даан хөгжих чадварыг эзэмшүүлэх, ажлын байранд шаардагдах ур чадварыг эзэмшүүлэх амьдралын чанарыг сайжруулах үндсэн чиглэлийг хэрэгжүүлдэг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант онд 4 чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ
- Хуулиар тусгайлан олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ
- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус төв нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудыг мөрдөж үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд төвийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 8, 12, 14, 16, 28, 57, 68, 70 дугаар зүйлүүдэд 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан;
- Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” 43 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;

Төвийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлсэнээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төв нь нягтлан бодох бүртгэл хөтөлөх, санхүүгийн тайлагналдаа Гэр Бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам-наас баталсан нягтлан бодох бүртгэлийг бодлогын баримт бичгийг хэрэглэж байна. НБББББ нь холбогдох хууль тогтоомж, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 143,831.9 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдэлгүй тул өөрчлөлт гараагүй болно.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	-	265.8	265.8
Үндсэн хөрөнгө	-	142,006.1	142,006.1
Биет бус хөрөнгө	-	1,560.0	1,560.0
<b>Нийт хөрөнгө</b>	-	<b>143,831.9</b>	<b>143,831.9</b>
Өр төлбөр	-	6,271.8	6,271.8
Хуримтлагдсан үр дүн	-	137,560.1	137,560.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	-	<b>143,831.9</b>	<b>143,831.9</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 142,006.1 мянган төгрөг болсон нь тайлант хугацаанд шинээр 78,144.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан. ТӨБЗГ-ын 2025 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн 271 дугаар тогтоолын дагуу “Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллага”-аас элэгдэлээрээ анхны өртгөө нөхсөн 112,000.0 мянган төгрөгийн балансын үнэ хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 6,000.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэн авсан байна. Мөн “Шинэ Үе Мэрси” ХХК-иас 4,960.0 мянган төгрөгийн үнэ бүхий тавилга эд хогшил, ГБХНЯ-аас 67,113.2 мянган төгрөгийн үнэ бүхий машин, тоног төхөөрөмж /компьютер/, албан хэрэгцээнд зориулж 2,476.1 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж /компьютер/ тус тус хандиваар хүлээн авснаар нэмэгдсэн байна, тайлант хугацаанд тооцсон 16,687.9 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийн зардлаар буурсан.
- Тайлант онд төлөх аудитын болон нийгмийн даатгал, бусад байгууллагад өгөх өглөг 6,271.7 мянган төгрөг байна.
- Засгийн газрын хувь оролцооны дансны үлдэгдэл нь тайлант оны 137,560.1 мянган төгрөгийн үр дүн байна.

Программ хангамжийн талаарх судалгаа авахад “Хас эрин орчил” ХХК-ийн “Динамик” төсөвт байгууллагын санхүүгийн программыг ашигладаг бөгөөд тайлант онд программ хангамжтай холбоотой 1,800.0 мянган төгрөгийн зардал гарсан болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,682,527.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил болон урсгал зардлын төсвийг 1,407,309.8 мянган төгрөгөөр бууруулж, 1,275,217.2 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,222,529.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 211,774.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,222,529.2 мянган төгрөг буюу 95.86 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 180,464.3 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 30,790.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 31,794.8 мянган төгрөг, нормативт зардлыг 2,753.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 4,921.2 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 1,202.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 6,251.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 5,433.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
72206	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгаалал	1,275,217.2	1,222,529.2	51,837.1	95.9
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,275,217.2	1,222,529.2	51,837.1	95.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- ХБХХЕГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/339 дүгээр тушаалаар тус төвийн бүтэц орон тоог 35 хүний бүрэлдэхүүнтэй баталсан бөгөөд 2025 онд шинээр үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэнтэй холбоотой цомхотгол хийгдээгүй байна.
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол, Хөдөлмөрийн дотоод журам 11.12.01 дэх заалтын дагуу хоол унааны зардлыг шинэчлэн нэг өдрийн 30.0 мянган төгрөгөөр тооцож 191,446.6 мянган төгрөгөөр төсөвлөж, тайлант онд гүйцэтгэлээр 152,925.2 мянган төгрөгийн зардал гарсан байна.
- Тайлант онд нийт 2 удаагийн сургалт зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнтэй холбоотойгоор 3,859.2 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах анхан шатны баримтын бүрдлийг хангах, зарцуулалтыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүлд-Аудит ХХК-ийн аудитор Г.Төрсайхан, Г.Баяржаргал, туслах аудитор Б.Хишигжаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер С.Лхагважав, захирал Ч.Гүндбаяр нар анхан шатны хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитын газрын ахлах аудитор Б.Ариунжаргал, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлын 1,275,217.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 19,128.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай бусад зардлыг хэмнэсэн, батлагдсан орон тооны хүрээнд ажиллаж, батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалтыг хийж гүйцэтгэсэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 1,394,430.9 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс, 1,394,430.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 702,940.9 мянган төгрөгийн 5 гүйлгээ, зардлын 691,490.0 мянган төгрөгийн 4 гүйлгээг тайлагнаагүй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны цахим хуудаст байршуулах мэдээллийг байршуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгөв.

#### 4.5 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, орлого, зардлын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар 20.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 25,675.0 мянган төгрөгийн 1 зөрчилтэй холбоотой анхан шатны баримтыг нөхөн бүрдүүлж, томилолтын зардалтай холбоотой 1 зөвлөмжийн биелэлт хангалтгүй учир тайлант оны зөрчилд оруулан аудитын тайланд тусгалаа.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх, дээд шатны байгууллага анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Төсвийн төлөвлөлтийг бодитой төлөвлөж байгааг хянах;
- Холбогдох санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хянах;

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,930.9 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 3 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Тендерээс орж ирсэн 1,890.0 мянган төгрөгийн орлого болон түүнтэй холбоотой 1,039.1 мянган төгрөгийн зардлыг орлого үр дүнгийн тайланд тусад нь биш цэвэр дүн болох 850.9 мянган төгрөгөөр тайлагнасан;
- Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогын дүнд 300.0 мянган төгрөгийн бараа материалын дүн оруулан тайлагнасан.
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн 3,780.0 мянган төгрөгийн зардлыг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гаргасан.

Эдгээр алдаа нь нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 119,130.0 мянган төгрөгийн 6 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1,032.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 25,612.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 92,485.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 119,130.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 100,001.7 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд албан томилолтоор ажилласан 6 албан хаагчийн томилолтын мөнгийг 1,032.4 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

томиллолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-т заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томиллолтоор ажилласан 6 албан хаагчийн томилолтын зардлыг илүү цагаар ажилласанд тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

## 5.2 Албан шаардлага

1. Тайлант онд гэрээт ажилтны тушаалыг үндсэн ажилтнаар гаргаж үндсэн цалин дээр хоол, унааны зардал 6,900.0 мянган төгрөгийг нэмж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээт ажилтанд хоол, унааны зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

2. Албан томилолтын зарцуулалтыг урьдчилгаа тооцоогоор тайлагнаагүй, гүйцэтгэлийг хянаагүй, 18,712.4 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын Зургаа. Тооцооны маягт нөхөх заавар”-ын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, анхан шатны баримтгүй гүйлгээ хийдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацааны цалингийн зардал нь НДШ-ийн тайлангаас 818.2 мянган төгрөгөөр, ХХОАТ-ын тайлангаас 2,975.3 мянган төгрөгийн тус тус зөрүүтэй тайлагнасан.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасантай, санхүүгийн тайлангийн үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн зардлыг нийгмийн даатгалын тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланд үнэн зөв, зөрүүгүй тайлагнаж байх

### 2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд хөрөнгө оруулалтын төсөв батлуулаагүй 79,944.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж орлогод авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж тус тус заасантай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Тайлант хугацаа бүрт хөрөнгө оруулалтын төсөв батлуулж, батлагдсан төсвийн дагуу зарцуулалт хийх.

### **3. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Цахим төлбөрийн и-баримтгүй 8,747.1 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоон дахь мэдээлэл нь холбогдох шийдвэр, эрх зүйн акт, нягтлан бодох бүртгэлийн баримтаар баталгаажсан байна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалт бүрт цахим төлбөрийн и-баримтыг шаардаж байх, анхан шатны баримтын бүрдэлд хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Тендерээс орж ирсэн 1,890.0 мянган төгрөгийн орлогыг орлого үр дүнгийн тайланд тайлагнаагүй. Тендерийн орлоготой холбоотой 1,039.1 мянган төгрөгийн зардлыг орлого үр дүнгийн тайланд тусад нь тайлагнаагүй цэвэр дүнгээр тайлагнасан.	1	850.9	1	850.9			1	850.9					
Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогын дүнд 300.0 мянган төгрөгийн бараа материалын дүн орсон байна.	1	300.0	1	300.0			1	300.0					
Зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн байна.	1	3,780.0					1	3,780.0					
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>4,930.9</b>	<b>2</b>	<b>1,150.9</b>	<b>1</b>	<b>3,780.0</b>	<b>3</b>	<b>4,930.9</b>					

/мянган төгрөгөөр/

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Гэрээт ажилтанд үндсэн ажилтны тушаал гаргаж хоол, унааны мөнгөнд 6,900.0 мянган төгрөг олгосон.	1	6,900.0										
Тайлант онд албан томилолтоор ажилласан 6 албан хаагчийн томилолтын	1	1,032.4	1	1,032.4								

/мянган төгрөгөөр/





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 75/A0150169

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд албан томилолтоор ажилласан 6 албан хаагчийн томилолтын мөнгийг 1,032,360.00 /нэг сая гучин хоёр мянга гурван зуун жаран/ төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-т заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв нь тайлант онд албан томилолтоор ажилласан 6 албан хаагчийн томилолтын мөнгийг 1,032,360.00 /нэг сая гучин хоёр мянга гурван зуун жаран/ төгрөгөөр илүү тооцож олгох шийдвэр гаргасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн дарга Ц.Ганчимэг-ээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн дарга /Ц.Ганчимэг/, ерөнхий нягтлан бодогч /Б.Азбилэг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  
АУДИТЫН МЕНЕЖЕР,  
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Ч.ГҮНДБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 378/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/260/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд гэрээт ажилтны тушаалыг үндсэн ажилтнаар гаргаж үндсэн цалин дээр хоол, унааны зардал 6,900,000.00 /зургаан сая есөн зуун мянган/ төгрөгийг нэмж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээт ажилтанд хоол, унааны зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн төсвийн шууд захирагч /Ц.Ганчимэг/, санхүүгийн ажилтан /Б.Азбилэг/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  
АУДИТЫН МЕНЕЖЕР,  
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР

Ч.ГҮНДБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 379/АД150169

Улаанбаатар хот

САГ - 2026 / 260 / ИА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан томилолтын зарцуулалтыг урьдчилгаа тооцоогоор тайлагнаагүй, гүйцэтгэлийг хянаагүй, 18,712,360.00 /арван найман сая долоон зуун арван хоёр мянга гурван зуун жаран/ төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, анхан шатны баримтгүй гүйлгээ хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн дарга /Ц.Ганчимэг/, ерөнхий нягтлан бодогч /Б.Азбилэг/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  
АУДИТЫН МЕНЕЖЕР:  
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР

Ч.ГҮНДБАЯР